

“БӨӨНИЙ ХУДАЛДАА” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 3 сарын 20 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай:

“Бөөний худалдаа” ХК-ийн 2026 оны 03 сарын 20-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн санал, Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60.1 дэхь заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 377 тоот тогтоолоор шинэчлэн батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг үндэслэн ТОГТООХ нь :

1. “Бөөний худалдаа” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2025 оны ээлжит хуралыг 2026 оны 04 сарын 30-ны 15:00 цагт БГД, 20-р хороо, Сонсголон, Бөөний худалдаа ХК-ийн байранд хуралдуулсугай.
2. “Бөөний худалдаа” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай
 - Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах
 - Ногдол ашиг хуваарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
 - 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах
3. Энэхүү ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг 2026 оны 04 сарын 09-ний өдөр (бүртгэлийн өдөр)-өөр тасалбар болгон ҮЦГХТ-с гаргасан жагсаалтын дагуу бүртгэн хуралд саналын эрхтэй оролцуулсугай.
4. Ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь “Бөөний худалдаа” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материалтай танилцах эрхийг ҮЦК-иудаар дамжуулан танилцах боломжоор ханган ажиллахыг ТУЗ-ийн нарийн бичигт үүрэг болгосугай.
5. Компанийн ээлжит хуралаар хэлэлцүүрэх асуудалаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2026 оны 04 сарын 25-ны өдрийн 16:30 минутаар тасалбар болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ДӨЛБАДРАХ